



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 5/62

Хэрлэн сум

Ажил хавсруулан гүйцэтгүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 30.1.15, 30.1.16, Хөдөлмөрийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 50 дугаар зүйлийн 50.2, 50.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Хурх тосгоны цэцэрлэгийн эрхлэгч Л.Энхтуяа нь өөр ажилд шилжсэн тул тус цэцэрлэгийн багш О.Урангоод 2017 оны 03 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн эрхлэгчийн үүргийг хавсруулан гүйцэтгүүлсүгэй.


Хоёр. Цэцэрлэгийн эрхлэгчийн ажлыг хүлээлцэх комисс томилон хүлээлцүүлэхийг тосгоны Захирагч /Г.Нацагдорж/-д даалгасугай.

Гурав. Эрхлэгчийн ажлыг хавсран гүйцэтгэх О.Урангоод үндсэн цалингаас нь 40 хувиар тооцон нэмэгдэл хөлс олгохыг цэцэрлэгийн нягтлан бодогч /Б.Оюунтуяа/-д зөвшөөрсүгэй.

Дөрөв. Эрхлэгчийн ажлыг мэргэжил арга зүй, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Боловсрол, соёл, урлагийн газар /С.Мөнхцэцэг/-т үүрэг болгосугай.

Тав. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /Г.Лхагвахатан/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА